



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

**Орон нутгийн төсөвт орсон байгалийн нөөц
ашигласны төлбөрөөс Байгаль хамгаалах
санд хөрөнгө төвлөрүүлээгүй байна**

Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Баян-Өлгий аймгийн аудитын газар Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Бекен Аудитын менежер Х.Женисбек Ахлах шинжээч К.Риза Шинжээч Х.Еркебулан 2015 оны 6 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 102, 106 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4 Бүлэг 1 Байгаль хамгаалах сангийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүн 5-9 <i>Орон нутгийн төсөвт орсон байгалийн нөөц ашигласны төлбөрөөс Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлээгүй байна</i> Бүлэг 2 Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт, үр дүн 10-12 <i>Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон ус ашиглах, бохир зайлуулах дүгнэлтгүй зарим байгууллагууд үйл ажиллагаа явуулж, холбогдох хуулиудыг зөрчсөн байна.</i> Дүгнэлт..... 13 Зөвлөмж: 14 Холбогдох байгууллагын санал: 15 Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар
--	---



Товчилсон үгийн тайлбар

БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БХС	Байгаль хамгаалах сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Аймгийн ИТХ-аас Үндэсний аудитын газрын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газарт гаргасан саналыг үндэслэн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Байгаль орчныг хамгаалах талаар гарсан хууль тогтоомжууд болон аймгийн ИТХ болон Засаг даргаас гарсан шийдвэрүүд, аймгийн БОАЖГазар, Сум дундын ойн ангийн 2013, 2014 онуудын үйл ажиллагааны тайлан, мэдээ хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийн тайлан, тооцоо судалгаануудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аймгийн БОАЖГазар, Сум дундын ойн анги болон МХГазрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, тайлбар лавлагаа авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Бүлэг 1

*Орон нутгийн төсөвт орсон байгалийн нөөц
ашигласны төлбөрөөс Байгаль хамгаалах санд хөрөнгө
төвлөрүүлээгүй байна*

Оршил

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгалийн унаган төрхийг хадгалах зорилгоор газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар зэрэг объектуудыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Иймд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь байгалийн дээрхи объектуудын тухай болон тэдгээрийг хамгаалахтай холбогдон гарсан хууль тогтоомжуудаас бүрдэнэ.

Байгаль хамгаалах тухай хуулинд аймаг, сумын ИТХ-ын болон Засаг дарга, баг, хорооны иргэдийн Нийтийн хурал болон Засаг даргын нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв батлах, биелэлтэнд хяналт тавих, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх бүрэн эрхийг тодорхойлсон байна.

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд хяналт тавих мэргэжлийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг мөн байгаль орчин, байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн байгууллагын чиг үүргийг дээрхи хуулиар зохицуулжээ.

1. Байгаль хамгаалах сангийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүн

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан аймгийн ИТХурлын болон Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд 2013 онд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар аймгийн БОАЖГазрын даргын “Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах” сэдэвт сонсголыг авч хэлэлцэж тодорхой чиглэл өгсөний дээр “Байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэн, зарцуулах, тайлагнах журам” батлан гаргаж 2013 онд 100,0 сая төгрөгийн, 2014 онд 150,0 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн төсвөөс зарцуулахаар тогтоол гаргажээ.

Уг тогтоолын дагуу 2013 онд Ховд голын эрэг орчимд 10 га газарт ойжуулалтын хашаа барихад 100,0 сая төгрөгийн, 2014 онд 25 га газарт ойн зурвас байгуулахад 150,0 сая төгрөгийн ажлыг тус тус аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлсэн байна.

Үүнээс гадна аймгийн ИТХ-ын тогтоолоор 2014 онд үр суулгац бэлтгэхэд зориулан Орон нутгийн орлогын давсан хэсгээс 10,0 сая төгрөгийг Сум дундын ойн ангид эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгожээ.

Байгаль хамгаалах сангаас ойжуулах, байгалийг нөхөн сэргээх ажилд зориулан 2013 онд хуваарилсан 55,6 сая төгрөгийг 14 арга хэмжээнд зарцуулахаар, 2014 онд хуваарилагдсан 82,6 сая төгрөгийг 8 арга хэмжээнд зарцуулахаар тус тус аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу батлан хэрэгжүүлсэн байна.

2012 онд шинэчилэн батлагдсан Ойн тухай хууль болон бусад холбогдох журам, тушаалын дагуу аймгийн Ойн байгууллагын бүтцийг боловсронгуй болгох, ойн аж ахуйн арга хэмжээг мэргэжлийн түвшинд явуулах боломжийг бүрдүүлэх үүднээс Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 49-р тогтоолоор Сум дундын ойн ангийг 6 хүний орон тоотойгоор байгуулсан ба орон орон нутгаас БОНХСайдад асуудал тавьж Ойн анги байгуулахад яамнаас 20,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор аймгийн хэмжээнд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах нөөцийн дээд хэмжээг тогтоож, газар нутгийн нэрээр зааж баталдаг байна. Тухайлбал: 2013 онд 9620 м.куб түлээ бэлтгэхээр, 2014 онд 4600 м.куб түлээ бэлтгэхээр ой бүхий сумдад хуваарилсан ба Толбо нуураас 10 тонн загас агнахаар тус тус хязгаар тогтоон баталжээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2013, 2014 онуудад мод суулгацны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, бүх нийтийн цэвэрлэгээний болон мод тарих өдөр бий болгох, байгаль хамгаалах чиглэлээр аймгийн хэмжээний сургалт, сурталчилгаа явуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Байгаль хамгаалах тухай хуулинд заасан эрх хэмжээний дагуу аймгийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, баялагийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, байгууллагын байгаль орчинд нөлөөлж буй үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоох арга хэмжээ авч ажилласан байна.

2013 онд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд ашигт малтмалын лицензтэй үйл ажиллагаа эрхлэх 9 компаны орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж, хандив тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, хяналт тавих үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг ажиллуулжээ.

2014 онд аймгийн Засаг даргын шийдвэрээр агаарын бохирдолын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж, явуулсан ажлын хэрэгжилтийг мэргэжлийн байгууллагаар хангуулжээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд заасан эрх хэмжээний дагуу эрх бүхий албан тушаалтнаас байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, баялагийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохиролыг нөхөн төлүүлэхээр тогтоосон нөхөн төлбөр болон байгалийн баялагийн нөөц ашигласны төлбөр, зөвшөөрсөн хэмжээнд хог хаягдал, бохирдуулах бодис гаргасны төлбөр хураамжийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 3, 55 дугаар зүйлийн 55.3-д заасны дагуу орон нутгийн төсөвт оруулж байгаа юм байна. Орон нутгийн төсөвт 2013 онд 73,5 сая төгрөгийн, 2014 онд 83,9 сая төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөр орсон байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэхь хэсэгт “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль хамгаалах санд оруулна”, Монгол Улсын засгийн газрын 1998 оны 188 тоот тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”-ын 2-д “Сан нь улсын төвлөрсөн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болж түүний орлого, зарлагын төсвийн төсөл, төлөвлөгөө гүйцэтгэлийн тайланд тусгагдана” гэж заасны дагуу орон нутагт орсон нөхөн төлбөр болон байгалийн нөөц ашигласны төлбөрөөс сан бүрдүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй байсан байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43-тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-аар байгалийн нөөц ашигласны төлбөрөөс тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хувь хэмжээгээр сан байгуулж, эргэж байгалийн нөхөн сэргээлтэнд зарцуулахаар заасан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 2014 онд Орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгөнөөс БОХСанд хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Иймд цаашид орон нутгийн төсөвт орсон байгалийн нөөц ашигласны төлбөр болон нөхөн төлбөрийн зохих хэсгийг тогтоолын дагуу санд төвлөрүүлэн эргээд тухайн нутаг дэвсгэрийн байгалийн нөхөн сэргээлтэнд зарцуулах талаар зөвлөмж өгөгдөв.

БОАЖЯамны тусгай зориулалтын сангаас тус аймагт байгаль орчны чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрийн санхүүжилтэнд зориулан 2013 онд БОАЖГазарт 27.6 сая төгрөгийн, аймгийн Сум дундын Ойн ангид 28.0 сая төгрөгийн нийтдээ 2013 онд 55,6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бол 2014 онд БОАЖГазарт 71,6 сая төгрөгийн, Сум дундын ойн ангид 11,0 сая төгрөгийн нийтдээ 82,6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоныг зориулалтын дагуу зарцуулжээ.

Мөн Ойн зурвас байгуулах ажилд ОНХСангаас 2013 онд 100,0 сая төгрөг, 2014 онд 150,0 сая төгрөг батлагдан ойн зурвас байгуулах, хашаа татах ажлыг 2013 онд “Интерренесеанс” ХХК гүйцэтгэж 12000 ширхэг мод тарьсан ба 2014 онд “Ховд-Сафари” ХХКомпани ойн зурвас байгуулах, хашаа татах ажлыг гүйцэтгэн 15000 ширхэг мод тарьж хүлээлгэн өгсөн байна.

2013 онд Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнгээр “Ногоон хэрэм” байгуулахад 5.5 сая төгрөгийн, ойн арчилгаанд 0.6 сая төгрөгийн, 9 сумд булаг шанд тохижуулахад 19.9 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийг БОАЖГазар эрх бүхий компаниудаар гэрээний үндсэн дээр хэрэгжүүлсэн ба 1.5 сая төгрөгийн үнэ бүхий “Arc Gis” программыг худалдаж авсан байна.

Сум дундын ойн анги нь 2013 онд Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, “Ногоон хэрэм”-ийн туслах зурвас байгуулах ажлын хүрээнд Ховд голын эрэг орчмын газрыг хамгаалах ойн зурвас байгуулах 20 га газарт 22.0 сая төгрөгийн тендер зарлаж “Интерренесеанс” ХХК гүйцэтгэсэн байна.

Үүнээс гадна Ойн ангид БОХСангаас хуваариласан хөрөнгөөр 20 га газарт хийгдэх ойжуулалтын ажлыг 6 компани, хоршооны хийсэн төслийг шалгаруулан ойжуулалтын ажлыг хийлгэсэн байна.

Тухайлбал: “Азых” ХХК 2 га талбайд Сагсай сумд 1560 ширхэг үхрийн нүд, чацаргана тарих ажлыг 0.6 сая төгрөгөөр, “Бекжанай” ХХК Алтанцөгц сумын Хан худаг хэмээх газарт 4 га талбайд 3200 ширхэг чацарганы таримал тарих ажлыг 1.2 сая төгрөгөөр, “Хатуугийн гол” ХХК Бугат сумын төвд 2 га талбайд 960 ширхэг чацаргана, улиас тарих ажлыг 0.6 сая төгрөгөөр, “Эрчим” ХХК, Өлгий сумын 8-р багт 6 га газарт нийтдээ 5100 ширхэг чацаргана, үхрийн нүд, улиас, бургас, хайлаас зэрэг таримал тарих ажлыг 1.8 сая төгрөгөөр, “Мураг” ХХК Өлгий сумын Хуст арал хэмээх газарт 2 га талбайд 1800 ширхэг таримал чацаргана тарих ажлыг 0.6 сая төгрөгөөр, “Хыран бүргэд” ЗБГХН Толбо сумын Өргөн ширэг гэдэг газарт гар аргаар хөрс боловсруулан улиас бургас, чацаргана зэрэг модны суулгац 3000 ширхэг тарих ажлыг 1.2 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэн нийтдээ 6,0 сая төгрөгийн ажил хийгдсэн байна.

2014 онд БОХСангаас БОАЖГазарт хуваариласан хөрөнгөөр аймгийн ан, агнуурын менежментийн төлөвлөгөө, агнуур зохион байгуулалт төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан “Анчдын нийгэмлэг” ТББайгууллага нь дээрхи менежментийн төлөвлөгөөг 35.0 сая төгрөгөөр гүйцэтгэж аймгийн нутаг дэвсгэрт байгаа ан, амьтныг хамгаалах, ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

Ойн зурвас байгуулах ажлын хүрээнд “Буыршын” ХХК 2.2 сая төгрөгийн, “Тазалык” ХХК 3.3 сая төгрөгийн, “Айтуар” ХХК 4.4 сая төгрөгийн нийтдээ 9 га газарт 9.9 сая төгрөгийн ойжуулалтын ажил хийхээр Сум дундын ойн ангитай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

Мөн мод үржүүлгийн талбайг өргөтгөх ажлыг “Айтуар” ХХКомпани 6.0 сая төгрөгөөр, мод үржүүлэх, хүлэмж авах ажлыг “Софтвермейнт” ХХКомпани 6.8 сая төгрөгөөр, байгаль хамгаалагч нарын албаны хэрэгцээнд зориулан мотоцикл, зургийн аппарат, компьютер, GPS зэрэг 9,9 сая төгрөгийн хөрөнгийг “ПГЖМ” ХХКомпаниас нийлүүлж, булгийн эх хамгаалах 4.0 сая төгрөг өртөг бүхий ажлыг “Өмир агаш крафт” ХХКомпани нь гүйцэтгэсэн байна.

Байгаль хамгаалах сангаас Ойн ангид хуваарилсан хөрөнгөөр Толбо чиглэлийн хар замын дагуу 10 га талбайд “Ногоон хэрэм”-ийн туслах зурвас байгуулах ажлыг нээлттэй тендерээр 11.0 сая төгрөгөөр “Буыршын” ХХК авч, нийтдээ 10 га-д 6000 ширхэг улиас, бургас, хайлаас модны суулгац тарьж, хашаа хамгаалалтыг хийж гүйцэтгэсэн.

Дээрх ойжуулалт, ойн зурвасуудыг улсын комисс хүлээж аваад акт материалуудыг хобогдох газруудад нь зохих хугацаанд нь хүргүүлж, 2014 онд аймгийн хэмжээнд нийтдээ 51514 ширхэг мод таригдсан гэсэн мэдээтэй байна.

2013, 2014 онуудад байгаль орчны чиглэлээр хэрэгжсэн ойжуулалт, ойн зурвас байгуулах талаар аймгийн төвд хэрэгжсэн 12 төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд газар дээр очиж үзэхэд жил бүрийн ойжуулалт хийсэн талбайг ялгаж тэмдэг тавиагүй, хувийн компани хийсэн ойжуулалтын ажил болон тус газрын ажилчдын хүчээр хийсэн ойжуулалтын ажлыг ялгаж салгаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Цаашид ойжуулалт хийсэн талбайг оноор нь ялгаж, гүйцэтгэгч байгууллагын нэр, санхүүжилтийн хэмжээ, хийсэн ажлын нэр, газрын талбай, тоо хэмжээ зэргийг тэмдэг хийж тэмдэгжүүлэх, төсөл хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Хэрэгжсэн төсөлт ажлуудыг “Ойжуулалтын ажлыг явуулах, шалгах, хүлээж авах журам” болон “Булаг шанд тохижуулах журам” зэрэг журмуудын хүрээнд шалгаж хяналт тавин хүлээн авч, байгаль хамгаалагч нарын албан хэрэгцээнд авсан болон мод үржүүлгийн талбайд авсан ойжуулалтын багаж хэрэгсэл, хүлэмжийг тухайн байгууллагуудын дансанд орлогод авсан байна.

Бүлэг 2

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон ус ашиглах, бохир зайлуулах дүгнэлтгүй зарим байгууллагууд үйл ажиллагаа явуулж, холбогдох хуулиудыг зөрчсөн байна.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт, үр дүн

БОАЖГазрын гаргасан тайлангаар байгаль орчныг хамгаалах, баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажилд 2013 онд 96 аж ахуйн нэгж, 43 байгууллага, 12600 иргэнийг хамруулан 62 зөрчил илрүүлэн арилгаж, 4201,4 мянган төгрөгийн торгууль, нөхөн төлбөр тавьж төлүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулахаар өгөгдсөн 15 албан шаардлагын биелэлтийг хангуулж, зөвшөөрөлгүй түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр болон бүр хугацаагаар зогсоосон ба зөрчил гаргасан 4 байгууллагад эрх бүхий байгууллагаар хариуцлага тооцуулан, 2 байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Дээрхи шалгалтанд 2014 онд 79 аж ахуйн нэгж, 114 байгууллага, 49197 иргэнийг хамруулж 95 зөрчил илрүүлэн 92 зөрчлийг ондоо багтаан барагдуулсаны дээр 10560,0 мянган төгрөгийн торгууль, 7749,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж 4468,0 мянган төгрөгийн торгууль, нөхөн төлбөрийг хугацаандаа барагдуулсан мэдээтэй байна.

Ховд голын ай сав газраас зөвшөөрөлгүй хууль бус хайрага ашигласан 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож зөрчил гаргасан 4 байгууллагад эрх бүхий байгууллагаар хариуцлага тооцуулахаар санал тавьж, 1 байгууллагыг мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

а. Аймгийн хэмжээнд уст цэгийн нэгдсэн тооллогыг 4 жилд нэг удаа хийж сүүлчийн тооллогыг 2011 онд хийсэн ба сумууд жил бүр уст цэгийн тооллогыг хийж мэдээг БОАЖГ-т ирүүлдэг байна. Нэгдсэн тооллогоор 131 гүн өрмийн худаг, 1838 гар худаг, 369 гол, горхи, 1220 нуур, тойром, 861 булаг шанд, 31 рашаан, мөсөн гол 128, усан сан, хөв цөөрөм 2, усалтын систем 16, цэвэрлэх байгууламж 1 байгаа гэсэн тооцоо гарчээ.

2014 онд “Аватекс-Хайнар” ХХК, “Дулаан хар” ХХК, “Суат “ ХХК зэрэг байгууллагуудад ус ашиглах дүгнэлт гаргасан байна.

б. “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ойн туслах зурвасыг 2005 оноос эхлэн бий болгох, орон нутгийн ойн зурвас бий болгох, ойгүй газрыг

ойжуулах, байгалын сэргэн ургалтанд туслах ажил буюу байгалийн ба хүний буруу үйл ажиллагаанаас доройтсон ойг нөхөн сэргээх, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, үйлдвэрийн плантаци байгуулах, мод үржүүлгийн талбай байгуулах зэрэг ажлууд хийгдэж байна.

в. Амьтны тухай хуулийн дагуу Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, Толбо нуурт Загасны нөөц тогтоох ажлуудыг эрх бүхий байгууллагуудаар хийлгэсэн байна

г. Орчны бохирдлын түвшний судалгаагаар азотын давхар исэл 2013 онд 29 удаа, 2014 онд 34 удаа зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан тохиолдол гарч бохирдлын түвшин жил бүр нэмэгдсэн байна. Агаарын бохирдлын түвшин нэмэгдэхэд машин техникийн хэрэглээ нэмэгдсэн ялангуяа ашиглалтын хугацаа дууссан хуучин машин техник их хэрэглэдэг, аймгийн төвийн нэгдсэн халаалтын системд холбогдоогүй аж ахуйн нэгж, иргэд үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээнд түүхий нүүрс их хэрэглэдэг, айл өрхийн тоо жил бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор ахуйн хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг байна.

Орчны бохирдлын эх үүсвэрийн тооллогоор 2014 онд аймгийн төвд ердийн галлагатай 10 квт хүчин чадалтай зуухны тоо 9754, усан халаалтын 11 квт-100квт хүчин чадалтай зуухны тоо 234, Дулааны цахилгаан станцын 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо- 4 байгаа ба нэг жилд 85987,1 мянган тонн нүүрс хэрэглэсэн тооцоо гарчээ.

Эдгээрээс аймгийн төвд 11-100 квт хүртэл хүчин чадалтай усан халаалтын зуух 68, хувийн орон сууц, байшингийн зуух 5530-ыг иргэд, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа гэсэн тооцоо гарч урьд онуудаас зуухны тоо 50-иар нэмэгдсэн байна.

Үүнд аймгийн төвийн хүн ам олширч хэрэглэгч нэмэгдсэнтэй холбоотойгоор нэгдсэн шугам сүлжээгээр халаалт өгч байгаа төвлөрсөн зуухны хүчин чадал хүрэлцэхгүйгээс үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд зайлшгүй нам даралтын зуух ашиглах явдал нөлөөлж байна гэсэн тайлбарыг холбогдох мэргэжилтэнээс өгч байна.

Гэвч “Эрчим” ХХКомпаны ашиглаж байгаа одоогийн зуух нь стандартын шаардлага хангасан шүүлтүүр ашиглахгүй байгаагаас шатсан нүүрсний 80 хувийг тоосонцор хөө хэлбэрээр агаар мандалд цацаж байна гэсэн тайлбарыг холбогдох мэргэжилтэн тайлбарлаж байна.

Аймгийн төвд хог хаягдлын цэгийг 2012 оноос ландфилийн аргаар барьж 2 жилийн хугацаатайгаар байгуулсан боловч уг цэг нь хог хаягдлыг өдөр тутам хөрсөөр дарж булах эрүүл ахуйн шаардлага хангаж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгаж хог хаягдлыг устгах боломжгүйгээс стандартын шаардлагыг бүрэн хангахгүй байгаа юм байна.

Химийн бодис хэрэглэж байгаа “Суат” ХХК, МХГазар, лабораторитой ЕБСургуулиудад хэрэглэж байгаа химийн бодисуудын хадгалалтанд хяналт тавьж ашиглалтгүй болсон 200 грамм мөнгөн усыг устгахаар шилжүүлсэн байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг БОАЖГазраас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэнд 3 жилийн хугацаатайгаар олгож, үйл ажиллагаанд өөрчлөлт, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн үед дахин үнэлгээнд хамруулдаг байна.

Мөн Усны тухай хуулийн 28 дугаар зүйлд хоногт 50 шоо метр хүртлэх ус ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны алба гаргахаар заасны дагуу ашиг олох зорилгоор ус ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд ус ашиглах дүгнэлт гаргуулан түүнийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулахаар заасан байна.

Дээрхи хуулиудад зааснаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон ус ашиглах дүгнэлт тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-ийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хийлгэх үүрэгтэй гэж заасан байдаг боловч иргэд үүргээ ухамсарлаагүйгээс нөлөөллийн үнэлгээ, дүгнэлт хийлгэхгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас хотын төв хэсэгт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүд ашиглаж байгаа уурын зуухаа үнэлгээнд хамруулах, ус ашиглах, бохир зайлуулах дүгнэлт гаргуулах ажил хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд заасан аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд зохих ажлууд хийгджээ.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон ус ашиглах, бохир зайлуулах дүгнэлтгүй зарим байгууллагууд үйл ажиллагаа явуулж, холбогдох хуулиудыг зөрчсөн байна.
3. Орон нутгийн төсөвт орж байгаа байгалийн нөөц ашигласны төлбөрөөс Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлээгүй байна.
4. Байгаль хамгаалах сангаас хуваариласан хөрөнгийг батлагдсан чиглэлээр нь зарцуулжээ.
5. Ойжуулалтын талбайд хийсэн ойжуулалтын ажлыг ойжуулалт хийгдсэн он оноор нь ялгаж тэмдэгжүүлээгүй байна.
6. Ойжуулалт хийх мэргэжлийн байгууллага байгуулагдсанаар ойжуулалтын ажлын хүрээнд зохих ажлууд хийгджээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Х.Дарменд:

1. Орон нутгийн төсөвт орж байгаа байгалийн нөөц ашигласны төлбөр болон нөхөн төлбөрийн зохих хэсгийг хууль, журмын дагуу байгаль хамгаалах санд төвлөрүүлэх нь зүйтэй;

2. Агаарын болон хөрсний бохирдлыг ялангуяа хотын төв хэсэгт байршилтай аж ахуйн нэгж,айл өрхүүдийн халаалтын зуухны агаар бохирдуулалтыг багасгахад анхаарлаа хандуулан уг ажилд эрх бүхий байгууллагуудын ажлыг чиглүүлэх шаардлагатай;

Тайланг баталгаажуулсан:

Баян-Өлгий аймаг дахь Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Х.Бекен

Тайланг хянасан:

Аудитын менежер Х.Женисбек

Тайланг бэлтгэсэн :

Ахлах шинжээч К.Риза
шинжээч Х.Еркебулан

Танилцсан :

БОАЖГазрын дарга Ш.Марат
Ня-бо Х.Тилеухан

